



МӨНГӨНМОРЬТ СУМЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Лавлах зүйл байвал 70272248
дугаарын утаснаас лавлана уу?

Дарга, Тэргүүлэх аудитор
Л.Жаргалсайхан
Өрөөний утас 70272582

Аудитын менежер
О.Амаржаргал
Өрөөний утас 70273465

Шинжээч
Ц.Хишигжаргал
Өрөөний утас 70273204

Аймгийн Аудитын газар
Төрийн байгууллагын ордон

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

• Аудит хийж дууссан тухай мэдэгдэл	2-3
• Танилцуулга	4
• Санхүүгийн дотоод хяналт	4-8
• Гол шийдлүүд	9
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	9
• Аудитын санал дүгнэлт	9

**Төв аймгийн Мөнгөнморьт сумын төсвийн байгууллагууд,
тусгай сангууд 2013 оны Санхүүгийн Тайланд
аудит хийж дууссан тухай мэдэгдэл**

Бид Мөнгөнморьт сумын төсөвт байгууллагууд болон тусгай сангуудын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба Сумын Засаг дарга болон төсвийн шууд захирагч болон Ерөнхий менежерт энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаархи бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мөнгөнморьт сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг тодруулбал:

- Орлого санхүүжилт, бараа ажил үйлчилгээний урсгал зардал, цалингийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгө авлага, мөнгөн хөрөнгө, өглөг бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

Гол илрүүлсэн зүйлс буюу аудитын үр дүнгээс гарсныг тодруулбал:

- Орон нутгийн төсвийн татварын орлогыг 37724.0 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 71881.4 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 34157.4 мянган төгрөгөөр буюу 190.5 хувиар давуулан биелүүлсэн байна.
- Сангийн нягтлан бодогчийн цалин, шимтгэлд 1278.7 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардалд 45.0 мянган төгрөг, 25.8 мянган төгрөгийг шатахууны зардалд олгосон байна.
- Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн үлдэгдлийг дансанд тусгаагүй байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХурлын 04-р хуралдаанаар 2013.03.13-ний өдрийн 01 тоот тогтоолоор төсөл хөтөлбөрт 252600.0 мянган төгрөгөөр баталсан. Аймгийн хэмжээнд олгох санхүүжилт буурсантай холбогдуулан 212891.3 мянган төгрөгийг баталсан байна. Мөн сумын ИТХурлын 2013.06.12 ны өдрийн 01 дугаар тогтоолоор ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын

төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

*ЕМ, Санхүүгийн албанаас
ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын
Газар тайлбар мэдүүлэг хүлээж байгаа
илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар
тайлбар ирүүлнэ үү*

Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн, дээрх зөрчлүүд материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага тул **Зөрчилгүй санал** дүгнэлт гаргахаар Тэргүүлэх аудиторт санал хүргүүлсэн байгаа.

ҮАГазрын харьяа Төв аймгийн Аудитын Газрын дарга, Тэргүүлэх Аудитор 2014.03.25-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад нягтлан бодогч, нярав болон бусад албан тушаалтан бидэнтэй хамтран ажиллаж бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

**ҮАГ-ЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

2014.03.25

Танилцуулга

Мөнгөнморьт сумын 2013 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитаа хийж дуусч байгаа ба сумын Засаг даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд сумын Засаг дарга нь тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Бидний 2013 оны тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Жилийн санхүүгийн тайланд аудит хийх;

Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Санхүүгийн дотоод хяналтыг дахин шалгах

Аймгийн Аудитын газар санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Мөнгөнморьт сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын хяналтыг аймгийн Аудитын газрын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм.

Бид Мөнгөнморьт сумын Засаг дарга тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Мөнгөнморьт сумын төсөвт байгууллагууд, тусгай сангуудын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

Орлого санхүүжилтийн талаар:

Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор сумын Орон нутгийн төсвийн татварын орлогыг 73526.9 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 92168.7 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөнөөс 18641.8 мянган төгрөгөөр буюу 125,3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Мөн аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 117994.8 мянган төгрөг, гүйцэтгэлээр 116427.8 мянган төгрөг буюу биелэлт 98.7 хувьтай, улсын төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөгөөр 4100.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 6561.4 мянган төгрөг биелэлт 160.0 хувиар тус тус биелэсэн байна.

Төрийн сангийн төлөөлөгчийн гаргаж ирүүлсэн 2013 оны орлого, санхүүжилтийн нэгдсэн тайлангаар /нүүр тайлан/ Сумын орон нутгийн орлогын данс оны эхэнд 7311.1 мянган төгрөг НЕҮ-ний харилцах дансны эхний үлдэгдэл 10355.9 мянган төгрөг нийт эхний үлдэгдэл 17667.0 мянган төгрөг байсан. Тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрөх орлогоор 92168.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 98.2 мянган төгрөг төвлөрсөн ба НЕҮ-ний санхүүгийн дэмжлэгээр 325725.0 мянган төгрөг нийт 435658.9 мянган төгрөг төвлөрч, 427518.5 мянган төгрөг зарцуулснаас санхүүгийн дэмжлэгээс ЗДТГазарт 262047.3 мянган төгрөг, ИТХуралд 31013.6 мянган төгрөг, Багт 31065.3 мянган төгрөг, Байгаль хамгаалах санд 12000.0 мянган төгрөг Орон нутгийн төсвөөс ЗДТГазарт 89013.7 мянган төгрөг, ИТХуралд 1689.6 мянган

төгрөг, Багуудад 689.0 мянган төгрөг буюу нийт мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдэл ОНОрлогын дансанд 8140.4 мянган төгрөг үлдсэн байна.

Тусгай зориулалттай шилжүүлгээр ЕБСургуульд 376858.4 мянган төгрөг, Цэцэрлэгт 181688.3 мянган төгрөг, Эмнэлэгт 190888.1 мянган төгрөг, Соёлын төвд 53913.3 мянган төгрөг нийт 803348.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг нэгтгэсэн байна. НЕҮйлчилгээний байгууллагуудын оны харилцах дансны үлдэгдэл 10355.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна

Халамжийн сангийн санхүүжилт 134488.0 мянган төгрөг төгрөгийг халамж үйлчилгээний санд төвлөрүүлснээс халамжийн тэтгэвэрт 100972.8 мянган төгрөг, жирэмсэн амаржсан эхийн тэтгэмжинд 25420.0 мянган төгрөг, хоол тэжээлийн тусламж дэмжлэгт 7410.2 мянган төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн зардалд 685.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн дансны санхүүжилтээр ЗДТГазарт 22156.6 мянган төгрөг, Сургууль 2253.4 мянган төгрөг, ЭМТөв 450.0 мянган төгрөг, Цэцэрлэг 300.0 мянган төгрөг, Соёлын төвд 1064.0 мянган төгрөг нийт 26224.3 мянган төгрөгийн орлого орж 25773.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж оны эцэст 450.4 мянган төгрөгийн үлдэгдэлийг мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд нэгтгэсэн.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор Тамгын газарт 98.2 мянган төгрөг, Соёлын төв 1934.9 мянган төгрөг, ЭМТөв 320.1 мянган төгрөг, Сургууль 392.3 мянган төгрөг, нийт 2736.4 мянган төгрөг нэгтгэгдсэн байна.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар оны эхэнд ЗДТГазар 8703.1 мянган төгрөг, ИТХурал 1147.2 мянган төгрөг, Баг 505.7 мянган төгрөг нийт 10356.0 мянган төгрөг, Тусгай зориулалтийн сангууд 63754.1 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 7311.1 мянган төгрөг, эм эргэлтийн сан 2638.8 мянган төгрөг, ЭМТөв 7.6 нийт 84067.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан.

Жилийн эцсийн байдлаар Тусгай зориулалтийн сангууд 48330.8 мянган төгрөг, Орон нутгийн орлогын данс 8140.4 мянган төгрөг, эм эргэлтийн сан 1869.0 мянган төгрөг, Нэмэлт төсвийн санхүүжилтийн дансны үлдэгдэл 450.4 нийт 58790.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна. Энэ Төрийн сангийн төлөөлөгчийн ирүүлсэн үлдэгдлийн баталгаагаатай болон ХААН банкнаас ирүүлсэн эм эргэлтийн сангийн үлдэгдлийн баталгаагаатай тохирч байна.

Авлага, өглөгийн талаар:

Сумын нэгдсэн тайлангаар Оны эхэнд 93910.5 мянган төгрөгийн авлага, оны эцэст 247307.7 мянган төгрөгийн авлагатай нэгтгэгдсэн ба оны эхнээс авлага 153397.2 мянган төгрөгөөр өссөн ба жилийн эцсийн нийт авлагын 234582.6 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 12500.0 мянган төгрөгийг Мал хамгаалах сангийн авлага тус тус эзэлж байна.

Оны эхэнд өглөггүй байсан оны эцэст 295.0 мянган төгрөгний өглөгтэй нэгтгэгдсэн байна. Оны эцэст Цэцэрлэг нь 290.0 мянган төгрөгний өглөгтэй байна

Бараа материал

Сумын нэгдсэн тайлангаар Бараа материалын данс нь оны эхэнд 91056.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 194601.1 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 192889.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, жилийн эцэст 92767.9 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө

Сумын нэгдсэн тайлангаар Үндсэн хөрөнгийн данс нь оны эхэнд 1650068.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 555517.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, 6957.7 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, жилийн эцэст 2198628.8 мянган төгрөгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Тусгай зориулалтын сангууд

Сумын хэмжээнд 5 сан үйл ажиллагаа явуулж байгаа ба эм эргэлтийн сангаас бусад сан Төрийн сангийн харилцах дансаар гүйлгээ хийгдэж хянагддаг байна. Сангуудыг тодруулахад:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн талаар:

Тус сангийн харилцах данс нь оны эхний үлдэгдэл 432.5 мянган төгрөг байснаас тайлант онд 369.1 мянган төгрөг төвлөрч 404.0 мянган төгрөг зарцуулж 397.6 мянган төгрөгний эцсийн үлдэгдэлтэй байна. ИТХ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын үлдэгдлийг тус санд төвлөрүүлсэн байна. Зарлагын хувьд хууль сурталчилах зардалд 172.0 мянган төгрөг, олон нийтийн байцаагчийн урамшуулалд 200.0 мянган төгрөг, шатахууны зардалд 32.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Байгаль хамгаалах сангийн талаар:

Тус сангийн эхний үлдэгдэл 85.7 мянган төгрөг байснаас тайлант оны турш 13732.5 мянган төгрөгний орлого санхүүжилт төвлөрч 12450.8 мянган төгрөг зарцуулж дансанд 1367.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар бүрдүүлсэн байна. Үүнд: Санхүүжилтээр 12000.0 мянган төгрөг, нөхөн төлбөр 290.0 мянган төгрөг, аймгаас ирсэн биотехнологийн арга хэмжээ 200.0 мянган төгрөг, БХамгаалагч нараас хуудасны үнэ 1208.9 мянган төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

2013 онд аймгийн төсвөөс 12000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирүүлснээс батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах зүйлд зарцуулсан байна. Үүнд:

1. Хог хаягдал 6000.0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс Нохой устгах зардалд 375.0 мянган төгрөг, Хог ачих шатахуунд 250.1 мянган төгрөг, Хогны машины жолоочийн урамшуулалд 886.2 мянган төгрөг, хогны машины сэлбэгт 1352.0 мянган төгрөг нийт 2863.3 мянган төгрөг зарцуулсан.
2. Эргүүл шалгалтанд 1300.0 мянган төгрөг зарцуулахаас 897.1 мянган төгрөгийг шатахуунд зарцуулсан байна.
3. Хяналт шалгалтын постын засварт 2000.0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 2000.0 мянган төгрөг зарцуулсан.
4. Усан сангийн засварт 1200.0 мянган төгрөг зарцуулахаас 1200.0 мянган төгрөг зарцуулсан.
5. Сургалт сурталчилгааны зардалд 500.0 мянган төгрөг зарцуулахаас 395.1 мянган төгрөг зарцуулсан.
6. Гамшгаас урьдчилан сэргийлэх морин эргүүлд урамшуулал 1200.0 мянган төгрөг
7. Бусад ойн ангийн засвар, БОУХБ-ын хувцас нийт 3200.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн 141552400 тоот дансыг Төрийн санд нээж тайланд онд 243887.2 мянган төгрөгийн орлого, 223794.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж жилийн эцэст харилцах дансанд 20093.1 мянган төгрөгний үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Орлогыг ня-бо-оос тодруулахад улсын төсвийн санхүүжилт 197486.1 мянган төгрөг, сумын 90-н жилийн ойд зориулсан хандив 44401.1 мянган төгрөг, аймгаас 2000.0 мянган төгрөгийн орлого нийт 243887.3 мянган төгрөг төвлөрсөн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх Хөрөнгө оруулалтын эрэмбэлсэн жагсаалтыг сумын ИТХурлын 04-р хуралдаанаар 2013.03.13-ний өдрийн 01 тоот тогтоолоор төсөл хөтөлбөрт 252600.0 мянган төгрөгөөр баталсан. Аймгийн хэмжээнд олгох санхүүжилт буурсантай холбогдуулан 212891.3 мянган төгрөгийг баталсан байна. Мөн сумын ИТХурлын 2013.06.12 ны өдрийн 01 дугаар тогтоолоор ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

Тайлант онд ОНХСангийн санхүүжилтэнд 197486.1 мянган төгрөгийг олгосон СТСХэлтсээс ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 20093.1 мянган төгрөг байна. Тайлант оны санхүүжилтээс ОНХСангаар хийгдсэн ажлыг жагсаавал:

1. Хогын цэгийн менежментийг сайжруулах хогын цэгийн талбайг багасгах 35000.0 мянган төгрөгний тендер шалгарсан гүйцэтгэл нь 35000.0 мянган төгрөг

2. Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулах өнгө үзэмжийг сайжруулах, гэр хороололын хаягжуулалт хийх

- Наадмын талбайг шинэчлэх 10000.0 мянган төгрөг шууд худалдан авалтаар

- Гудамжны видео дэлгэц 21532.8 мянган төгрөг

- Нийтийн бие засах газар 2000.0 мянган төгрөг

- Наадмын талбайд асар барих 5000.0 мянган төгрөг

3. Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт

- Цэцэрлэгт хүрээлэнгийн хашааны доод хэсгийг блокоор бөглөх зам тавих, ногоон байгууламж нэмэгдүүлэх мод тарих зам тавих сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбай байгуулахад тендерийн үнэ 35000.0 мянган төгрөг гүйцэтгэл нь 34999.7 мянган төгрөг

- Ёслол хүндэтгэлийн гэр 15000.0 мянган төгрөг

- Чимэд арслангийн хөшөө зөөвөрлөх суурилуулах 3000.0 мянган төгрөг

- Үүлэн бор азарганы хөшөө 2000.0 мянган төгрөг

- Цэцэрлэгт хүрээлэнгийн гэрэлтүүлэг 3000.0 мянган төгрөг

4. Гудамжны гэрэлтүүлэг тендерийн үнэ 35000.0 мянган төгрөг гүйцэтгэл 29999.9 мянган төгрөг

5. Урьд ухаагийн сумын бэлэгдэл тендерийн үнэ 20000.0 мянган төгрөг гүйцэтгэлээр 19922.9 мянган төгрөг

6. Сумын төвийн замын засвар Булгын голын гүүр 2000.0 мянган төгрөг

7. Баяр наадмын зардалд 5000.0 мянган төгрөг зэрэг ажлууд хийгдсэн байна.

Мал хамгаалах сангийн талаар:

Тайлант хугацаанд мал хамгаалах сангийн харилцахын эхний үлдэгдэл 591.5 мянган төгрөг байсан ба тайлант онд 2848.0 мянган төгрөгний орлого төвлөрсөн байна. Үүнд:

2013 онд өвс тэжээл, будаа соломны үнэ 2640.5 мянган төгрөг, бэлчээр ашигласаны төлбөрт 207.5 мянган төгрөг тус тус төвлөрсөн байна. Нийт 513.2 мянган төгрөгний зарлага гарснаас Малчдын зөвөлгөөнд 376.1 мянган төгрөг, шатахууны зардалд 137.1 мянган төгрөг

тус тус зарцуулсан байна. 2013 оны эцсийн үлдэгдэлд 2925.9 мянган төгрөг байна. Мал хамгаалах сангийн өвс тэжээлийн үлдэгдлийг дансанд тусгаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

Сум хөгжүүлэх сан нь оны эхэнд 62644.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба санхүүгийн дэмжлэг 50000.0 мянган төгрөгийн эх үүсвэр авсан, зээл зээлийн хүүний эргэн төлөлтөөс 53951.6 мянган төгрөг нийт 103951.6 мянган төгрөг төвлөрсөн байна Тус сангаас 143049.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэнээс 29 хүнд 141700.0 мянган төгрөгийн зээлийг олгосон ба Сангийн нягтлан бодогчийн цалин, шимтгэлд 1278.7 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардалд 45.0 мянган төгрөг, 25.8 мянган төгрөгийг шатахууны зардалд олгосон байна. 2013 оны жилийн эцсийн үлдэгдэлд 23546.9 мянган төгрөг байна.

Байгаль орчин нөхөн сэргээлтийн сангийн талаар:

Байгаль орчны нөхөн сэргээлтийн санд ямар ч гүйлгээ хийгдээгүй байна.

Бидний дахин шалгалтын үр дүнд дээр дурдсан хэсгүүдийн дотоод хяналтын систем нь тухайн жилд хангалттай байсан ба нягтлан бодох бүртгэл нь Санхүүгийн тайлангийн зохистой үндэс болсон нь ажиглагдсан юм. Сайжруулах шаардлагатай байж болох хэд хэдэн санхүүгийн хяналтын талаар хавсралт бүхий удирдлагын захидалд тусгасан болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
- Санхүүгийн тайлан гаргалт уялдаа холбоог сайжруулах
- МУ-ын ЗГазрын 2012.11.09-ний өдрийн 311-р тогтоолыг хэрэгжүүлэн байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг батлан мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

1. Аудитын стандарт нь Аймгийн Аудитын газарт аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар илрүүлсэн алдаануудыг төсөвт байгууллагуудад залруулсан ба нэгтгэлд залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

2. Аудитын үйл явцад Аймгийн Аудитын газар хөндлөнгийн аудиторовн хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн даргаас эдгээр батлагааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

3. Аймгийн Аудитын газраас танай байгууллагын 2013 оны 12 дугаар сарын 31 –нээр тасалбар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.03.22